



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 42

Төрийн ордон, Улаанбаатар хот

## Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байнгын, дэд хороодын саналыг харгалзан жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо (Ж.Бат-Эрдэнэ)-нд даалгасугай.

3.Эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах бүх үе шатанд Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг шалгуур болгон хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахад дүн шинжилгээ хийн үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодод үүрэг болгосугай.

4.Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга (Б.Баасандорж)-д даалгасугай:

1/Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгуулах;

2/Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил тутам мониторинг, хоёр жил тутамд үр нөлөөний үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо (Ж.Бат-Эрдэнэ)-нд танилцуулах.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Монгол Улсын Их Хурлын алсын хараа**

Монгол Улсын Их Хурал эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлж, хүн төвт бодлогыг эрхэмлэн, Монголын ард түмний засаглах эрхийг хангана.

### **Монгол Улсын Их Хурлын эрхэм зорилго**

Монгол Улсын Их Хурал нийт иргэн, үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэсэн, тогтвортой хөгжил, инновацад тулгуурласан, нээлттэй, олон ургалч үзлийг хангасан парламент байна.

### **Монгол Улсын Их Хурлын үнэт зүйлс**

- Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах;
- Олон ургалч үзэл, төлөөллийг хангах, үр нөлөөтэй байх;
- Ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх, иргэдийн оролцоог хангах;
- Ёс зүйтэй, хариуцлагатай, хариуцан тайлагнадаг байх.

**Стратегийн зорилго 1. Монгол Улсын Их Хурал хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ.**

#### **Стратегийн зорилт:**

1.1. Монгол Улсын Их Хурал хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатанд хүн төвт үзэл санаанд суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх зарчим, шаардлагыг тэргүүн эрэмбэд тавина.

1.2. Монгол Улсын Их Хурал ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулан, иргэдийн санал бодлыг сонсож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудын тэгш оролцоог хангана.

1.3. Монгол Улсын Их Хурал олон талт түншлэлийг хөгжүүлж, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд хууль тогтоох ажиллагаанд хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлнэ.

#### **Хүрэх үр дүн:**

1. Хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байна.

2. Хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, хүн төвт үзэл санаанд суурилсан арга барил, хууль зүйн техникийг нэвтрүүлсэн байна.

3.Хууль тогтоомжийн төслийг боловсруулах, хэлэлцэх, баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих үйл явцад иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах тогтолцоо бүрдсэн байна.

**Стратегийн зорилго 2.Монгол Улсын Их Хурал үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжсэн, цаг үеийн шаардлага, нийгмийн амин чухал эрэлт, хэрэгцээг тооцсон цогц шийдвэр гаргана.**

**Стратегийн зорилт:**

2.1.Хууль тогтоомж нь Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа, залгамж чанарыг хангасан, харилцан туршлага, судалгаа, нотолгоо, хууль хэрэглээний практикт суурилсан байна.

2.2.Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомжийн үр нөлөөг тогтмол судлан, түүний үр дүнг үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгож хэвшинэ.

2.3.Нийгэм, эдийн засагт шинэ тутам үүсэж байгаа харилцаа, цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах урт хугацааны санах ой бүхий байнгын тогтолцоог бүрдүүлнэ.

**Хүрэх үр дүн:**

1.Монгол Улсын Их Хурлаас батлан гаргах хууль тогтоомж үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, тогтвортой хөгжлийг дэмжсэн байна.

2.Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын уялдаа холбоо хангагдаж, үр нөлөө дээшилсэн байна.

3.Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хариуцлагын тогтолцоо бэхжиж, хэрэгжилт хангагдсан байна.

4.Нийгмийн харилцаанд тулгамдсан тодорхой асуудлыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлэхдээ судалгаа, дүн шинжилгээ, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээнд үндэслэж хэвшсэн байна.

**Стратегийн зорилго 3.Монгол Улсын Их Хурал шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг дэмжинэ.**

**Стратегийн зорилт:**

3.1.Хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, олон нийтээр хэлэлцүүлэх, батлах, биелэлтэд хяналт тавих, олон нийтэд сурталчлах бүх үе шатанд шинжлэх ухаанд суурилан инновац, технологийн дэвшлийг дэмжинэ.

3.2.Их өгөгдөлд суурилсан мэдээлэл, дүн шинжилгээг шийдвэр гаргахад үр өгөөжтэй ашиглана.

3.3.Цахим парламентыг хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, кибер аюулгүй байдлыг хангана.

#### **Хүрэх үр дүн:**

1.Хууль тогтоомж нь шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшлийг дэмжсэн байна.

2.Шийдвэр гаргахад их өгөгдөлд суурилсан мэдээлэл, дүн шинжилгээг ашиглах, кибер аюулгүй байдал хангагдах тогтолцоо бүрдсэн байна.

3.Мэдээлэл солилцох, хуулийн төсөл дээр ажиллах, судалгаа хөгжүүлэлт хийх, хяналт тавих цахим системүүдийг нэвтрүүлж, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө нэмэгдсэн байна.

**Стратегийн зорилго 4.Олон ургалч үзэл бүхий дэвшилтэт, шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ.**

#### **Стратегийн зорилт:**

4.1.Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаанд олон ургалч үзлийг хөхиүлэн дэмжиж, цөөнхийн саналыг хүндэтгэн, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг бэхжүүлж, Улсын Их Хурлын гишүүд төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4.2.Иргэд Улсын Их Хурлын гишүүдтэй олон талт сувгаар холбогдох нөхцөлийг сайжруулж, гишүүд сонгогчдын өмнө ажлын гүйцэтгэл, ёс зүйтэй байдлаа хариуцан тайлагнадаг тогтолцоог төлөвшүүлнэ.

4.3.Ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэн, хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, сонгох, сонгогдох эрхийг бэхжүүлэх, хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн, бүх нийтэд хүртээмжтэй, ёс зүйтэй, соён гэгээрүүлэгч, дэвшилтэт, шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ.

#### **Хүрэх үр дүн:**

1.Монгол Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал дээшилж, парламентад итгэх иргэдийн итгэл бэхэжсэн байна.

2.Хууль тогтоох үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагааг хялбаршуулж, мэдээлэл солилцох, зөвшилцөх, олон нийтийн оролцоог хангах үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцоог бэхжүүлсэн байна.

**Стратегийн зорилго 5.Монгол Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлнэ.**

#### **Стратегийн зорилт:**

5.1.Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, парламентын боловсрол олгох, сурталчлан таниулахад нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн дэвшилтэт арга, хэрэгсэл ашиглана.

5.2.Монгол Улсын Их Хурлын гадаад харилцаа, парламент, бүс нутгийн ба олон улсын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.3.Хүний эрхийг хангах олон улсын механизмыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.

5.4.Дэвшилтэт, шинэ үеийн парламентын хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, өндөр бүтээмжит ажлын албыг бэхжүүлнэ.

### **Хүрэх үр дүн:**

1.Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж сайжирч, парламентын боловсрол олгох тогтолцоо бүрдсэн байна.

2.Олон улсын хэмжээнд Монгол Улсын Их Хурлын нэр хүнд улам бүр дээшилж, байр суурь бэхэжсэн байна.

3.Монгол Улсын Их Хурал, нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын албаны чадавхыг бэхжүүлсэн байна.

---oOo---